ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

**АУДИТЫН КОД: АХГ-2022/21/НА-СТА-ТТЗ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.


**Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг**
**Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn**
**Аудитын менежер: Г.Гүнжидмаа**
**Утас:261885 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn**
**Ахлах аудитор: А.Даваадорж**
**Утас:261628 Цахим хаяг:davaadorja@audit.gov.mn**
**Аудитор: Г.Мөнхчимэг**
**Утас:261628 Цахим хаяг:munkhchimegg@audit.gov.mn**



Улаанбаатар хот
2022 он

**Агуулга**

1. Аудитын гэрчилгээ ..... 2
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан ..... 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан ..... 5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 8
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ..... 10
3. Аудитын тайлан ..... 12
3.1. Ерөнхий зүйл ..... 12
3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ..... 12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт ..... 12
3.4 Материаллаг байдал ..... 13
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт ..... 13
3.5.1 Мөнгөн хөрөнгө ..... 13
3.5.3 Авлага ..... 13
3.5.6 Бараа материал ..... 14
3.5.7 Үндсэн хөрөнгө ..... 14
3.5.8 Өр төлбөр ..... 15
3.5.9 Засгийн газрын хувь оролцоо ..... 15
3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ..... 15
3.7 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 16
3.7.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ..... 16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга ..... 17
3.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ..... 17
4. Аудитын илрүүлэлт ..... 18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ..... 0

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| БОАЖС | Байгаль орчин, аялал жуулчлалын сайд |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| УЦУОШТ | Ус, цаг уур, орчны шинжилгээний төв |
| ТТЗ | Төсвийн төвлөрүүлэн захирагч |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.03.25 № 07/699

танай ____________-ны № ____________-т

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА С.ЭНХТҮВШИН ТАНАА

Аудитын санал дүгнэлт

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Цаг уур, орчны шинжилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилтын хүрээнд арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 95.6 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ Я.САРАНСҮХ

9006109
9019120596

## 2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2020 оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | 8,530,879.3 | 15,238,540.6 |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 11,077.3 | 1,596,139.6 |
| **33** | **АВЛАГА** | 43,856.3 | 1,307,136.7 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 8,475,945.7 | 12,335,264.3 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | 25,617,929.5 | 27,767,847.0 |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 25,617,929.5 | 27,767,847.0 |
| **39200** | **Биет хөрөнгө** | 16,729,377.2 | 18,890,684.2 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | 8,888,552.3 | 8,877,162.8 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | 34,148,808.8 | 43,006,387.6 |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | 7,587.4 | 1,583,516.4 |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 7,587.4 | 1,583,516.4 |
| **41300** | **Өглөг** | 7,587.4 | 1,583,516.4 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | 34,141,221.4 | 41,422,871.2 |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 34,141,221.4 | 41,422,871.2 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 25,682,747.1 | 25,693,349.1 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | 3,770,140.5 | 11,162,449.2 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 4,688,333.8 | 4,567,072.8 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | 34,148,808.8 | 43,006,387.6 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2020 оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 50,076,847.6 | 41,944,502.3 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 14,936,462.8 | 4,490,014.8 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 14,936,462.8 | 4,490,014.8 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 35,140,384.9 | 37,454,487.5 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 42,671,469.1 | 34,528,618.1 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 42,671,469.1 | 34,528,618.1 |
| 210 | БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 39,784,988.5 | 33,079,813.8 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 23,136,003.4 | 22,852,942.9 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 3,036,828.0 | 3,025,107.1 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 880,484.9 | 895,513.4 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 1,294,301.6 | 854,264.4 |
| 2105 | Норматив зардал | 48,866.9 | 105,102.3 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 7,204,790.8 | 603,254.4 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 179,488.7 | 119,300.9 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,247,008.4 | 1,133,552.9 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,757,215.9 | 3,490,775.5 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 2,886,480.6 | 1,448,804.4 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 7,405,378.5 | 7,415,884.1 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 14,488.2 | 133,038.8 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | 7,390,890.4 | 7,282,845.3 |

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

| **Код:** | **Тайлангийн үзүүлэлт** | **2020 оны 12-р сарын 31** | **2021 оны 12-р сарын 31** |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | 35,368,489.9 | 39,219,225.9 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | 105,749.1 | 1,717,255.9 |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 105,749.1 | 1,717,255.9 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 35,262,740.7 | 37,501,970.0 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 35,112,797.4 | 32,863,704.2 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 35,112,797.4 | 32,863,704.2 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 32,124,161.7 | 31,368,927.5 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 23,125,359.8 | 22,852,721.2 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 3,045,412.0 | 3,031,682.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 883,346.2 | 907,801.2 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 529,245.5 | 438,443.8 |
| **2105** | **Нормативт зардал** | 68,919.5 | 75,182.9 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,067,214.3 | 2,825,399.5 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 179,502.2 | 122,484.8 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,097,351.8 | 1,030,112.9 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 127,810.5 | 85,099.4 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 2,988,635.8 | 1,494,776.8 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | 255,692.4 | 6,355,521.7 |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | 260,201.6 | 4,770,459.3 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | 260,201.6 | 4,770,459.3 |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 260,201.6 | 4,770,459.3 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | (260,201.6) | (4,770,459.3) |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | (4,509.1) | 1,585,062.4 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 15,586.4 | 11,077.3 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 11,077.3 | 1,596,139.6 |

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|---|
| **1** | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 26,645,175.4 | | 26,645,175.4 |
| **2** | **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт** | 188,332.7 | | 188,332.7 |
| **3** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 26,833,508.1 | | 26,833,508.1 |
| **4** | **Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт** | (94,988.8) | | (94,988.8) |
| **5** | **Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт** | 11,811.7 | | 11,811.7 |
| **6** | **Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз** | - | | - |
| **7** | **Өмчид гарсан өөрчлөлт** | - | | - |
| **8** | **Зарласан ногдол ашиг** | - | | - |
| **9** | **Тайлант үеийн үр дүн** | 7,390,890.4 | | 7,390,890.4 |
| **10** | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 34,141,221.4 | | 34,141,221.4 |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 109,463.4 | | 109,463.4 |
| **13** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 34,250,684.8 | | 34,250,684.8 |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | (121,261.0) | | (121,261.0) |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 10,602.0 | | 10,602.0 |
| 16 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | | - |
| 17 | Өмчид гарсан өөрчлөлт | - | | - |
| 18 | Зарласан ногдол ашиг | - | | - |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 7,282,845.3 | | 7,282,845.3 |
| **20** | **2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | 41,422,871.2 | | 41,422,871.2 |

### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **31,429,688,200.00** | **31,138,180,948.58** | **291,507,251.42** | **99.1** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **31,429,688,200.00** | **31,138,180,948.58** | **291,507,251.42** | **99.1** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **30,379,253,900.00** | **30,115,735,985.58** | **263,517,914.42** | **99.1** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **22,568,183,700.00** | **22,387,945,498.86** | **180,238,201.14** | **99.2** |
| 210101 | Үндсэн цалин | 15,635,693,300.00 | 15,516,734,571.06 | 118,958,728.94 | 99.2 |
| 210102 | Нэмэгдэл | 6,022,706,500.00 | 5,982,058,548.19 | 40,647,951.81 | 99.3 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 909,783,900.00 | 889,152,379.61 | 20,631,520.39 | 97.7 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **3,046,704,800.00** | **2,971,570,826.95** | **75,133,973.05** | **97.5** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 2,143,977,400.00 | 2,087,758,992.73 | 56,218,407.27 | 97.4 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 225,681,900.00 | 224,170,439.65 | 1,511,460.35 | 99.3 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 180,545,500.00 | 179,478,172.58 | 1,067,327.42 | 99.4 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 45,136,200.00 | 43,801,547.36 | 1,334,652.64 | 97.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 451,363,800.00 | 436,361,674.63 | 15,002,125.37 | 96.7 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **886,706,900.00** | **882,511,473.68** | **4,195,426.32** | **99.5** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 417,923,000.00 | 415,683,496.58 | 2,239,503.42 | 99.5 |
| 210302 | Түлш, халаалт | 423,370,400.00 | 422,928,690.10 | 441,709.90 | 99.9 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 38,512,800.00 | 37,596,262.00 | 916,538.00 | 97.6 |
| 210304 | Байрны түрээс | 6,900,700.00 | 6,303,025.00 | 597,675.00 | 91.3 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **248,413,100.00** | **245,739,802.54** | **2,673,297.46** | **98.9** |
| 210401 | Бичиг хэрэг | 36,450,900.00 | 36,433,728.00 | 17,172.00 | 100.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 112,398,800.00 | 112,385,281.00 | 13,519.00 | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 55,977,900.00 | 53,667,790.54 | 2,310,109.46 | 95.9 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,424,800.00 | 3,123,400.00 | 301,400.00 | 91.2 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 40,160,700.00 | 40,129,603.00 | 31,097.00 | 99.9 |
| **2105** | **Норматив зардал** | **49,614,400.00** | **49,589,630.00** | **24,770.00** | **100.0** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 34,460,100.00 | 34,460,050.00 | 50.00 | 100.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 15,154,300.00 | 15,129,580.00 | 24,720.00 | 99.8 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **2,765,453,900.00** | **2,765,423,744.11** | **30,155.89** | **100.0** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,742,304,700.00 | 2,742,285,074.11 | 19,625.89 | 100.0 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 4,622,400.00 | 4,613,400.00 | 9,000.00 | 99.8 |
| 210604 | Урсгал засвар | 18,526,800.00 | 18,525,270.00 | 1,530.00 | 100.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **58,582,100.00** | **58,460,180.00** | **121,920.00** | **99.8** |
| 210702 | Дотоод албан томилолт | 58,582,100.00 | 58,460,180.00 | 121,920.00 | 99.8 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **710,715,000.00** | **709,620,157.44** | **1,094,842.56** | **99.8** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 569,878,700.00 | 569,427,298.44 | 451,401.56 | 99.9 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 10,598,200.00 | 10,585,700.00 | 12,500.00 | 99.9 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 19,629,900.00 | 19,516,342.00 | 113,558.00 | 99.4 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 4,217,000.00 | 4,038,585.00 | 178,415.00 | 95.8 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 1,638,400.00 | 1,582,945.00 | 55,455.00 | 96.6 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 46,073,700.00 | 46,069,463.00 | 4,237.00 | 100.0 |
| 210807 | Газрын төлбөр | 26,556,600.00 | 26,277,324.00 | 279,276.00 | 98.9 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 32,122,500.00 | 32,122,500.00 | 0.00 | 100.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **44,880,000.00** | **44,874,672.00** | **5,328.00** | **100.0** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 37,583,600.00 | 37,580,541.00 | 3,059.00 | 100.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,296,400.00 | 7,294,131.00 | 2,269.00 | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,050,434,300.00** | **1,022,444,963.00** | **27,989,337.00** | **97.3** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **1,050,434,300.00** | **1,022,444,963.00** | **27,989,337.00** | **97.3** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 45,988,900.00 | 45,988,860.00 | 40.00 | 100.0 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 1,004,445,400.00 | 976,456,103.00 | 27,989,297.00 | 97.2 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **31,429,688,200.00** | **31,138,180,948.58** | **291,507,251.42** | **99.1** |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **31,359,758,200.00** | **31,002,903,827.63** | **356,854,372.37** | **98.9** |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 31,359,758,200.00 | 31,002,903,827.63 | **356,854,372.37** | **98.9** |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **69,930,000.00** | **135,277,120.95** | **(65,347,120.95)** | **193.4** |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 39,730,000.00 | 66,208,750.00 | (26,478,750.00) | 166.6 |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 30,200,000.00 | 69,068,370.95 | (38,868,370.95) | 228.7 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **3,812** | **3,782** | **30** | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **26** | **26** | **0** | |
| 610001 | Төсвийн байгууллага | 26 | 26 | **0** | |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **1,893** | **1,878** | **15** | |
| 620001 | Удирдах ажилтан | 63 | 63 | **0** | |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 1,699 | 1,686 | **13** | |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 131 | 129 | **2** | |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **1,893** | **1,878** | **15** | |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 29 | 22 | **7** | |
| 650005 | ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ) | 29 | 29 | **0** | |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 1,835 | 1,827 | **8** | |

### 4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,940,348,239.32** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,870,526,688.32** |
| **210** | **БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,755,049,243.94** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **464,775,661.00** |
| 210101 | Үндсэн цалин | 462,350,661.00 |
| 210104 | Урамшуулал | 2,425,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **60,111,128.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 60,111,128.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **26,415,722.94** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,886,957.78 |
| 210302 | Түлш, халаалт | 15,123,561.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,405,204.16 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **196,407,761.84** |
| 210401 | Бичиг хэрэг | 27,777,763.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 107,739,255.57 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 26,092,068.27 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 217,160.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 34,581,515.00 |
| **2105** | **Норматив зардал** | **25,593,311.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 5,894,237.00 |
| 210502 | Хоол, хүнс | 918,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 18,781,074.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **470,999,670.86** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 172,269,852.50 |
| 210602 | Тавилга | 6,310,500.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 2,514,750.00 |
| 210604 | Урсгал засвар | 289,904,568.36 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **64,024,573.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 64,024,573.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **400,036,934.18** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 356,316,067.78 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,739,700.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 101,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 25,300.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 33,896,592.40 |
| 210807 | Газрын төлбөр | 7,958,274.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **46,684,481.12** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 46,364,481.12 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 320,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **115,477,444.38** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **67,500,941.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 22,739,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 44,761,441.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **47,976,503.38** |
| 213305 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт,нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 47,976,503.38 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **69,821,551.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **69,821,551.00** |
| 221001 | Их засвар | 69,821,551.00 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,943,441,847.51** |

| | | |
|---|---|---|
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **1,943,441,847.51** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 1,048,349,577.79 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 77,396,682.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 423,155,779.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 394,539,808.72 |
| **III** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | **66,162,697.79** |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 11,067,279.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 14,160,887.19 |

## 3. Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Цаг уур, орчны шинжилгээний газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн харьяа байгууллагуудын дотоод хяналтыг сайжруулах талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 03 дугаар сарын 05-аас 2022 оны 03 дугаар сарын 25-ны хооронд Үндэсний аудитын газрын аудитор Г.Мөнхчимэг, ахлах аудитор А.Даваадорж, нар гүйцэтгэж чанарын хяналтыг аудитын менежер Г.Гүнжидмаа, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Сарансүх нар хэрэгжүүлсэн.

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 01/103 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Цаг уур, орчны шинжилгээний газар эрхэм зорилгоо “Ус, цаг агаар, байгаль орчны төлөв байдалд байнгын хяналт шинжилгээ хийж, бодит болон урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллээр нийгмийн хэрэгцээг шуурхай хангах, байгалийн болзошгүй гамшгийн эрсдэлээс сэрэмжлүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Цаг уур, орчны шинжилгээний газар үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

- Монгол Улсын хэмжээнд ус цаг уур, байгаль орчны төлөв байдал чанарын хяналт шинжилгээг зохион байгуулж, хэрэглэгчийг мэдээллээр шуурхай хангах, ус, цаг агаарын аюултай үзэгдлийн улмаас үүсэж болзошгүй гамшгийн эрсдэлээс эртнээс сэрэмжлүүлэх;
- Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээг нэгдсэн удирдлага, нэгдмэл арга зүйгээр хангах, өргөжүүлэх, чадавхыг бэхжүүлэх;
- Ус, цаг уур, байгаль орчны чанарын хяналт, шинжилгээний улсын сүлжээний үйл ажиллагааг тасралтгүй явуулж, мэдээлэл цуглуулах, түүнийг хэрэглэгчдэд шуурхай хүргэх техникийн найдвартай ажиллагааг хангах, техник технологийн байнгын шинэчлэл хийх;
- Ус, цаг уур, байгаль орчны архив, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх ажлыг удирдан зохион байгуулах, хэрэглэгчдийг мэдээллээр үйлчлэх.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Цаг уур, орчны шинжилгээний газар нь санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу шинэчилсэн байна.

Цаг уур, орчны шинжилгээний газрын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### *3.4* Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар буюу 716.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 11.1 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 1,596.1 сая төгрөг болж, 1,585.0 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Касст байгаа бэлэн мөнгө | | | |
| Банканд байгаа бэлэн мөнгө | 11,077.3 | 1,596,139.6 | 1,585,062.3 |
| **Дүн** | | | |

*Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газрын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1,596.1 сая төгрөг нь Дундговь аймгийн УЦУОШТ-ийн ахмадын БОАЖС-ын 2021 оны “Хөрөнгө оруулалтын эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх барилга угсралтын ажил, арилжааны банкан дахь харилцах дансны үлдэгдэл байна.

### 3.5.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 43.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 1,307.1 сая төгрөг болж, 1,263.3 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №.2 Авлагын үлдэгдэл* *\/мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Ажиллагчидтай холбогдсон авлага | 1,200.0 | 393.9 | -806.1 |
| Төлбөртэй үйлчилгээний авлага | 0 | 240.0 | 240.0 |
| Татаас, санхүүжилтийн авлага | 39,258.2 | 45,876.6 | 6,618.4 |
| Зээлийн хүүгийн авлага | | | |
| Бусад авлага | 3,398.1 | 1,260,626.1 | 1,257,228.0 |
| Зээлийн авлага | | | |
| **Дүн** | **43,856.3** | **1,307,136.6** | **1,263,280.3** |

*Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газрын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар харьяа 8 байгууллагын 1,307.1 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Үүнд:

- Говьсүмбэр УЦУОШТ 0.02 сая төгрөг, Дорноговь 0.4 сая төгрөг, Орхон УЦУОШТ 0.2 сая төгрөг, Ус, цаг уур, орчны шинжилгээний төв 0.4 сая төгрөгийн ажиллагчидтай холбогдсон авлага;

- Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн гадаад төслийн төсвийн үлдэгдэл 45.9 сая төгрөгийн татаас санхүүжилтийн авлага;
- Хэнтий аймгийн УЦУОШТөв 13.8 сая төгрөгийн хувь хүмүүсээс авах авлага;
- Дундговь УЦУОШТ 2.4 сая төгрөг, Цаг уур, орчны шинжилгээний газар 1,244.4 сая төгрөгийн авлага үүссэн шалтгаан нь Ковид-19 цар тахлын улмаас БНХАУ-ын хил хаадаснаас үүссэн цаг уурын хэмжих хэрэгсэл болон цаг агаарт нөлөөлөх пуужингийн авлага байна.

### 3.5.6 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 8,475.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 12,335.3 сая төгрөг болж, өмнөх оныхоос 3,859.4 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №.3 Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Тусгай зориулалтын материал | 6,063,404.0 | 5,861,619.9 | -201,784.1 |
| Эм боох | 35,090.1 | 13,602.9 | -21,487.2 |
| Дуусаагүй үйлдвэрлэл | 21,206.1 | 4,221,206.1 | 4,200,000.0 |
| Бэлэн бүтээгдэхүүн | 3,505.0 | 2,313.0 | -1,192.0 |
| Бичиг хэргийн материал | 93,823.9 | 100,113.7 | 6,289.8 |
| Аж ахуйн материал | 518,433.9 | 513,026.9 | -5,407.0 |
| Сэлбэг хэрэгсэл | 1,059,071.6 | 966,191.9 | -92,879.7 |
| Түлш шатах тослох материал | 51,323.6 | 28,960.7 | -22,362.9 |
| Барилгын засвар | 22,248.8 | 21,807.4 | -441.4 |
| Бусад хангамжийн материал | 579,817.1 | 578,715.9 | -1,101.2 |
| Мал, амьтад | 28,021.6 | 27,705.9 | -315.7 |
| **Дүн** | **8,475,945.7** | **12,335,264.3** | **3,859,318.6** |

*Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газрын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Бараа материалын үлдэгдэлд 3,859.4 сая төгрөгийн Цаг уур, орчны шинжилгээний газарт эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтаар баригдаж буй барилга байгууламж, тоног төхөөрөмжийн ажлыг дуусах хүртэл хүлээн авсан гүйцэтгэлийн дүнгээр бусад эргэлтийн хөрөнгөд бүртгэж тайлагнасантай холбогдолтойгоор өссөн үзүүлэлтэй гарсан байна.

Харьяа байгууллагууд үйл ажиллагаандаа ашиглах боломжгүй 326.1 сая төгрөгийн бараа материалыг акталж, устгасан байна.

### 3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 25,617.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 27,767.8 сая төгрөг болж, 2,149.9 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Барилга байгууламж, орон сууц | 9,088,705.1 | 9,227,716.9 | 139,011.8 |
| Тээврийн хэрэгсэл | 1,377,378.7 | 1,290,975.4 | -86.403.3 |
| Машин тоног төхөөрөмж | 5,884,104.1 | 7,901,666.5 | 2,017,562.4 |
| Тавилга эд хогшил | 223,107.4 | 336,428.2 | 113,320.8 |
| Батлан хамгаалахын тоног төхөөрөмж | 0 | | |
| Номын фонд | 3,253.5 | 3,253.5 | 0 |
| Бусад үндсэн хөрөнгө | 152,828.2 | 130,643.4 | -22,184.8 |
| Программ хангамж | 193,884.6 | 211,868.8 | 17,984.2 |
| Бусад биет бус хөрөнгө | 8,694,667.8 | 8,665,294.0 | -29,373.8 |
| **Дүн** | **25,617,929.4** | **27,767,846.7** | **2,149,917.3** |

*Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газрын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд үндсэн хөрөнгө данс нь төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 570.5 сая төгрөг, балансаас баланст шилжүүлэн авсан 298.2 сая төгрөг, бусад байгууллага, бусад эх

үүсвэрээс авсан 3,981.3 сая төгрөгийн хөрөнгө тайлагнаснаас харьяа 5 байгууллагад 377.6 сая төгрөгийн барилга, байгууламж, 3 байгууллагад 95.3 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, үлдэх өртөггүй үндсэн хөрөнгийг дахин үнэлснээс 3,508.4 сая төгрөг, 1 байгууллага 10.6 сая төгрөгийн газар эзэмших эрхийг үнэлж, дахин үнэлгээний нэмэгдлээр бүртгэсэн байна.

Балансаас балансt шилжүүлсэн 86.4 сая төгрөг, 1 байгууллагын авто тээврийн хэрэгслийг 14.6 сая төгрөгөөр дуудлага худалдаагаар худалдсан, акталсан 1,426.1 сая төгрөг, шилжүүлсэн хөрөнгө 86.4 сая төгрөг, бусад 7,521.9 сая төгрөгөөр хасагдсан байна.

### 3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 7.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 1,583.5 сая төгрөг болж, 1,575.9 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өссөн+ Буурсан - |
|---|---|---|---|
| *Богино хугацаат өр төлбөр дүн* | 7,587.4 | 1,583,516.4 | 1,575,929.0 |
| Ажилчидтай холбогдсон өглөг | 7,587.4 | 1,529.7 | -6,057.7 |
| Байгууллагад төлөх өглөг | | 1,581,986.7 | 1,581,986.7 |
| **Нийт дүн** | **7,587.4** | **1,583,516.4** | **1,575,929.0** |

*Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газрын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Ус, цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн 0.9 сая, Баянхонгор УЦУОШТ 0.5 сая төгрөг, Говьсүмбэр УЦУОШТ 0.2 сая төгрөг, Орхон УЦУОШТ 0.7 сая төгрөг ажилчидтай холбогдсон өглөг, Говьсүмбэр УЦУОШТ 0.8 сая төгрөг, Цаг уур, орчны шинжилгээний газар 1,582.0 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байгаа нь БОАЖС-ын 2021 оны “Хөрөнгө оруулалтын эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх барилга угсралтын ажил, хөрөнгө оруулалтын олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдлийг Засгийн газрын 2021 оны 397 дугаар тогтоолын дагуу барьцаа хөрөнгийн дансанд байршуулсныг тухайн байгууллагуудад өглөгөөр тусгаж тайлагнасан байна.

### 3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 34,141.2 сая төгрөгийн эцсийн үлдэгдэл 41,422.9 сая төгрөг болж, 7,281.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 6. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт/+/, бууралт /-/ |
|---|---|---|---|
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 25,682,747.1 | 25,693,349.1 | 10,602.0 |
| **Хуримтлагдсан үр дүн** | **3,770,140.5** | **11,162,449.2** | **7,392,308.7** |
| Өмнөх үеийн үр дүн | -3,620,749.8 | 3,879,603.9 | 258,854.1 |
| Тайлант үеийн үр дүн | 7,390,890.3 | 7,282,845.3 | -108,045.0 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 4,688,333.8 | 4,567,072.8 | -121,261.0 |
| **Дүн** | **34,141,221.4** | **41,422,871.1** | **7,281,649.7** |

*Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газрын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

## 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 35,117.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 3,333.2 сая төгрөгөөр урсгал зардлыг бууруулж, 31,784.6 сая төгрөгөөр салбарын урсгал зардлыг баталсан боловч Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалж, 2021 оны 4 дүгээр сард төсөвт тодотгол хийж, салбарын төсвийг 401.4 сая төгрөгөөр хассан байна.

БОАЖЯ-аас 2021 оны 12 дугаар сард Хэнтий аймгийн УЦУОШТ-ийн шинэ барилгын ашиглалтын зардалд 43.3 сая төгрөг, Булган аймгийн УЦУОШТ-д 3.0 сая төгрөг нэмж олгосон зэрэг өөрчлөлт орж, 31,429.6 сая төгрөгөөр баталсан байна.

**Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөрт зориулан урсгал зардалд 31,429.6 сая төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 31,359.7 сая төгрөгийг улсын төсвөөс, 69.9 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 31,429.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 356.8 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

БОАЖЯ-аас эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын 6,209.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээнд 2021 онд 4,509.0 сая төгрөгийн санхүүжилт баталснаас гүйцэтгэлээр 2,926.4 сая төгрөгийн санхүүжилт олгож, 1,476.4 сая төгрөгийг барьцаа дансанд, 105.5 сая төгрөгийг захиалагчийн хяналтын дансанд төвлөрүүлсэн байна.

**Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламж, гадаад төсөл хөтөлбөрөөс 1,048.4 сая төгрөг, Засгийн газрын нөөц сан 77.4 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 486.2 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 394.5 сая төгрөг, нийт 2,006.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс урсгал зардалд 1,895.4 сая төгрөг, хөрөнгийн зардалд 63.1 сая төгрөг, нийт 1,958.5 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 48.0 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

### 3.7 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.7.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих 146 мэдээллээс 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 21.1 сая төгрөгийн 1 албан шаардлага, 674.5 сая төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

### 3.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тайлант онд 1,582.0 сая төгрөгийн БОАЖС-ын 2021 оны хөрөнгө оруулалтын эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх барилга угсралтын ажил, хөрөнгө оруулалтын олгоогүй санхүүжилтийн үлдэгдэл, Засгийн газрын 2021 оны 397 дугаар тогтоолын дагуу барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан хөрөнгийн зарцуулалтыг анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 26 төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэснээс 23 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 байгууллагыг аудитын түүвэрт хамруулсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын 22 санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, Орхон аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 1,026.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 144.5 сая төгрөгийн 26 алдааг аудитын явцад залруулж, 3.0 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 804.5 сая төгрөгийн 25 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 74.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 31 зөвлөмжийг хүргүүллээ.

### 4.1 Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн албан шаардлага

Харьяа байгууллагуудын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 881.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6 "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж заасныг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

**Шийдвэрлэсэн нь**: Дотоод аудитын үйл ажиллагааг сайжруулах, илэрсэн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах талаар албан шаардлага өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

### 5.1 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| № | Байгууллагын нэр | Аудитын санал дүгнэлт | | | Алдаа зөрчлийн ангилал | | | | | | | | Нийт алдаа, зөрчлийн дүн | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Үгнээс | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Залруулга | | | |
| | | Түүвэрт | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Тоо | Дүн /мян.төг/ | Тоо | Дүн /мян.төг/ | Тоо | Дүн /мян.төг/ | Тоо | Дүн /мян.төг/ | Тоо | Дүн /мян.төг/ |
| 1 | Цаг уур, орчны шинжилгээний газар | - | - | - | - | - | 1 | - | 1 | - | 0 | - | 2 | - |
| 2 | Архангай аймаг УЦУОШТ | - | 1 | - | - | - | 1 | - | 0 | - | 1 | 15,200.0 | 2 | 15,200.0 |
| 3 | Баян-Өлгий аймаг УЦУОШТ | - | 1 | - | - | - | 0 | - | 0 | - | 1 | 507.2 | 1 | 507.2 |
| 4 | Баян хонгор аймаг УЦУОШТ | - | 1 | - | - | - | 0 | - | 2 | 4,206.1 | 0 | - | 2 | 4,206.1 |
| 5 | Булган аймаг УЦУОШТ | - | 1 | - | - | - | 0 | - | 3 | 4,999.7 | 0 | - | 3 | 4,999.7 |
| 6 | Говь-Алтай аймаг УЦУОШТ | - | 1 | - | - | - | 5 | 10,300.0 | 0 | - | 0 | - | 5 | 10,300.0 |
| 7 | Говь Сүмбэр аймаг УЦУОШТ | - | 1 | - | - | - | 3 | 819.3 | 1 | - | 4 | 2,608.1 | 8 | 3,427.4 |
| 8 | Дархан аймаг УЦУОШТ | - | 1 | - | - | - | 0 | - | 1 | 981.4 | 0 | - | 1 | 981.4 |
| 9 | Дорнод аймаг УЦУОШТ | - | 1 | - | - | - | 1 | 400.0 | 2 | 19,300.0 | 1 | 41,600.0 | 4 | 61,300.0 |
| 10 | Дорноговь аймаг УЦУОШТ | 1 | - | - | - | - | 0 | - | 3 | - | 0 | - | 3 | - |
| 11 | Дундговь аймаг УЦУОШТ | - | 1 | - | - | - | 1 | 1,229.8 | 0 | - | 2 | 26,998.4 | 3 | 28,228.2 |
| 12 | Завхан аймаг УЦУОШТ | - | 1 | - | - | - | 0 | - | 1 | 7,800.0 | 0 | - | 1 | 7,800.0 |
| 13 | Орхон аймаг УЦУОШТ | - | - | 1 | - | - | 3 | 17,379.9 | 5 | 184.5 | 1 | 2,430.3 | 9 | 19,994.7 |
| 14 | Өвөрхангай аймаг УЦУОШТ | - | 1 | - | - | - | 1 | 474.9 | 0 | - | 0 | - | 1 | 474.9 |
| 15 | Өмнөговь аймаг УЦУОШТ | - | 1 | - | - | - | 0 | - | 5 | 4,946.3 | 1 | 2,744.9 | 6 | 7,691.2 |
| 16 | Сүхбаатар аймаг УЦУОШТ | - | 1 | - | 1 | 3,036.6 | 1 | 9,973.5 | 1 | - | 2 | 10,788.6 | 5 | 23,798.7 |
| 17 | Сэлэнгэ аймаг УЦУОШТ | - | 1 | - | - | - | 0 | - | 3 | 22,740.6 | 0 | - | 3 | 22,740.6 |
| 18 | Төв аймаг УЦУОШТ | - | 1 | - | - | - | 3 | 10,223.6 | 1 | 2,135.2 | 2 | 7,916.8 | 6 | 20,275.6 |
| 19 | Увс аймаг УЦУОШТ | - | 1 | - | - | - | 0 | - | 0 | - | 0 | - | 0 | - |
| 20 | Ховд аймаг УЦУОШТ | - | 1 | - | - | - | 0 | - | 1 | 1,098.8 | 0 | - | 1 | 1,098.8 |
| 21 | Хөвсгөл аймаг УЦУОШТ | - | 1 | - | - | - | 0 | - | 1 | 5,800.0 | 1 | 3,200.0 | 2 | 9,000.0 |
| 22 | Хэнтий аймаг УЦУОШТ | - | 1 | - | - | - | 3 | 752,120.0 | 0 | - | 3 | 15,800.0 | 6 | 767,920.0 |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 23 | Улаанбаатар УЦУОШТ | 1 | - | - | - | - | 0 | - | 0 | - | 0 | - | 0 | - |
| 24 | Ус, цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн | - | 1 | - | - | - | 2 | 1,511.1 | 0 | - | 7 | 14,751.8 | 9 | 16,262.9 |
| 25 | Байгаль орчин хэмжил зүйн төв лабораторийн | - | 1 | - | - | - | 0 | - | 1 | - | 0 | - | 1 | - |
| 26 | Нислэгийн цаг уур | 1 | 1 | - | - | - | 0 | - | 0 | - | 0 | - | 0 | - |
| **Дүн** | | **3** | **22** | **1** | **1** | **3,036.6** | **24** | **804,432.1** | **31** | **74,192.6** | **26** | **144,546.1** | **82** | **1,026,207.4** |

## 5.2 Нийцлийн аудитын асуудлаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

| д/д | Байгууллагын нэр | Аудитын код | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Залруулга | | Акт | | Албан шаардлага | | Хариуцлага тооцох | | Зөвлөмж | |
| | | | тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн | тоо | дүн | тоо | дүн | Тоо | дүн |
| 1 | Цаг уур, орчны шинжилгээний газар | АХГ-2022/21/НА-СТА-ТТ3 | | | | | | | | | | | 1 | - |
| **Дүн** | | | | | | | | | | | | | **1** | **-** |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25 № 679/А0170074 Улаанбаатар хот
АХГ-2022/211НА-СТА-ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Цаг уур, орчны шинжилгээний газрын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Харьяа байгууллагуудын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 881,661,300.00 төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6 "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж заасныг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дотоод аудитын үйл ажиллагааг сайжруулах, илэрсэн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга С.Энхтүвшин, Ахлах нягтлан бодогч Д.Отгонбаяр нарт хариуцуулав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

| | |
|---|---|
| АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | Г.ГҮНЖИДМАА |
| АХЛАХ АУДИТОР | А.ДАВААДОРЖ |
| АУДИТОР | Г.МӨНХЧИМЭГ |

9019120396

ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ

......................................................................................................................................................................

......................................................................................................................................................................

......................................................................................................................................................................

......................................................................................................................................................................

......................................................................................................................................................................

......................................................................................................................................................................

......................................................................................................................................................................

......................................................................................................................................................................

......................................................................................................................................................................

......................................................................................................................................................................

......................................................................................................................................................................

......................................................................................................................................................................

......................................................................................................................................................................

......................................................................................................................................................................

......................................................................................................................................................................

......................................................................................................................................................................

......................................................................................................................................................................

......................................................................................................................................................................

......................................................................................................................................................................

......................................................................................................................................................................

......................................................................................................................................................................

......................................................................................................................................................................

......................................................................................................................................................................

......................................................................................................................................................................

......................................................................................................................................................................

......................................................................................................................................................................

......................................................................................................................................................................

......................................................................................................................................................................

......................................................................................................................................................................

ТЭМДЭГЛЭЛ